

БОДЛОГЫН УЯЛДААГҮЙ ХӨГЖИЛ БА ХҮНИЙ ЭРХ

1. Илтгэлийг¹ ТББ-уудын судалгаа, мониторингийн тайланд үндэслэн боловсруулж, Хүний эрхийн ТББ-дын Форум (ХЭФ)-ын хэлэлцүүлэг, ажлын хэсгийн уулзалтууд, 10 аймагт зохион байгуулсан орон нутгийн хэлэлцүүлэг, үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр танилцуулж, санал авсан болно. Мөн НҮБ-ын болон олон улсын бусад механизмаас өгсөн зөвлөмж, саналыг харгалзан үзсэн.
2. Өмнөх хэлэлцүүлгээс байгаль орчин ба нүүдэлч хүн ам, шилжин суурьшигчдын талаар 8 зөвлөмж хүлээн авсан ч үр дүн гараагүй², асуудал улам гүнзгийрч нүүдэлч малчдын уламжлалт мал аж ахуй эрхлэх боломж улам хомсдож, хот сууринг бараадсан хэсгийнх нь шилжин суурьших, газар өмчлөх, эзэмших, тогтвортой амьжиргаатай байх эрхүүд зөрчигдөж³ байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, салбаруудын хөгжлийн бодлого өөр хоорондоо болон ТХЗ, Ногоон хөгжлийн бодлого, мөн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, хүний эрхийн чиглэлээр олон улсын хэмжээнд авсан үүрэг амлалттай уялдахгүй байгаатай холбоотой.
3. МУ нь уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, байгаль экологи ба төрөл зүйлийг хамгаалах тухай 10 гаруй конвенц, дагалдах протоколд⁴ нэгдэж, хэрэгжүүлэх хөтөлбөр болон амлалтаа боловсруулсан. Гэвч Байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээ (БОГҮ)-г НҮБ-ын ЕЭЗК (UNEP)-оос хийсэн үнэлгээнд “...хэдийгээр Монгол Улс ...байгаль хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлсэн ч хэрэгжилт нь хангалтгүй... Мөн Ногоон хөгжлийн бодлоготой боловч Стратегийн нөлөөллийн үнэлгээг (СНҮ) салбаруудын нөлөөллийг үнэлэхэд хэрэгжүүлээгүй байна” гэж дүгнэсэн.⁵ Мөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 5.1-р зүйлд “аливаа хөгжлийн хөтөлбөр, бодлого боловсруулахад стратегийн нөлөөллийн үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд хүн амын эрүүл мэндэд болон нийгэмд нөлөөлөх үнэлгээ хийх”, 17-р зүйлд “сөрөг нөлөө бүхий төсөлд банк, санхүүгийн байгууллагууд санхүүжилт олгохгүй байх” тухай заасан ч уул уурхай, эрчим хүчийг хөгжүүлэх бодлогыг төлөвлөхөд эдгээр заалтыг мөрдөхгүй байгаа нь хөгжлийн бусад бодлого, зорилт, нэн ялангуяа хүний эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөөр байгааг энэхүү тайланд өгүүлнэ.

Нүүрсний өрсөлдөөнд манлайлая⁶

4. АХБ, ЕХОБ, ЕСБХБ ба Уур амьсгалын ногоон сангийн “Гэр хорооллын хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих”⁷ төсөл нь нийслэлийн агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилготой. Тус төсөл нь 2040 он гэхэд МУ-ын хүн амын 64% Улаанбаатарт шилжин сууна гэсэн таамаглал

¹ - ХЭ Форумын хүрээнд ажлын хэсэг нь 2015 оноос хойш UPR-ын зөвлөмжүүдийг хүлээж авах, Засгийн газрын төлөвлөгөө гаргах үйл явц болон хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийж холбогдох яам агентлагуудтай тогтмол мэдээлэл солилцож ажилласан болно.

² -108.162. НҮБ-ын Бизнес болон хүний эрхийн асуудлаарх үндсэн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс нүүдэлчин малчдын нөхцөл байдал, эрхээ сэргээлгэх боломжийг сайжруулахад онцгой ач холбогдол өгсөн Бизнес болон хүний эрхийн асуудлаарх Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр бий болгох /Нидерланд/ зөвлөмж хэрэгжээгүй

³ 108.144. Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах /Испани/

⁴ https://www.mne.mn/?page_id=454

⁵ 2017-2018 онд байгаль орчны гүйцэтгэлийн үнэлгээг ТХЗ-дыг хэрэгжүүлэхэд чиглэж байгаа эсэхэд үнэлгээ хийгээд <https://www.legalinfo.mn/law/details/8665>

⁶ Coal Mongolia 2019 –Өрсөлдөөнд манлайлая уриан дор явагдсан - <https://www.coalmongolia.mn/>

⁷ <https://www.greenclimate.fund/documents/20182/893456/16910> - ADB - [Ulaanbaatar Green Affordable Housing and Resilient Urban Renewal Project_AHURP .pdf](https://www.greenclimate.fund/documents/20182/893456/16910), хуудас 4

болон нүүрсээр галлаж агаар бохирдуулж буй гэр хорооллын өрхүүдийг орон сууцанд шилжүүлэх замаар асуудлыг шийдэх зорилтын хүрээнд орон сууцжуулах төслүүдийг зээлээр санхүүжүүлж байна. Үүний дунд шинэ хорооллуудын⁸ дулаан, цахилгааныг хангах зорилгоор нүүрсний 3 дулааны станц (122.5 Mw) барих, мөн Эрчим хүчний дунд хугацааны хөтөлбөр⁹ (ЭХДХХ)-т УБ-ын ДЦС 2,3,4-ийн хүчин чадлыг 48%-иар нэмэгдүүлэх, эдгээрийг нүүрсээр хангах Багануурын уурхайг өргөтгөхөөр шийдвэрлэсэн. Эдгээр зорилт хэрэгжвэл агаарын бохирдол буурахгүй, харин одоогийн CO₂eq 7.2 сая тонн дээр 6.1 сая тонн CO₂eq хүлэмжийн хийн хаягдлыг нэмж үйлдвэрлэнэ (Хавсралт 1). ЭХДХХ нь төлөвлөсөн ёсоор хэрэгжвэл уур амьсгалын өөрчлөлтийг хязгаарлах Үндэсний тодорхойлсон зорилт (NDC)-ын хүлэмжийн хийн ялгарлыг 14%-иар бууруулах амлалтаас ухарч, нийт 60 сая тонн CO₂eq хүрч одоогийн түвшнийг 2 дахин нэмэгдүүлнэ. Мөн ЭХДХХ нь нүүрсний хүчин чадлыг 150% нэмэгдүүлж, нар, салхины суурилуулах хүчин чадлыг 65%-иар бууруулсан нь 2030 он гэхэд эрчим хүчний суурилагдсан хүчин чадлын 30%-ийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах амлалт биелэхгүйд хүрсэн. (Хавсралт 2-ээс үзнэ үү). Үүний зэрэгцээ ДЦС-аас агаарт хаягдах PM_{2.5} болон бусад элемент нэмэгдэж хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөр байхад СНҮ хийгдээгүй бөгөөд энэ нь ТХЗ-3.9¹⁰, 13.2-ыг хэрэгжүүлэх амлалттай зөрчилдөж байна.

5. Түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон ЗГ-ын 62-р тогтоол¹¹ эмзэг бүлэгт хэрхэн нөлөөлөхийг үнэлээгүй бөгөөд хязгаарлалтын бүсийг тогтоосон үндэслэл тодорхойгүй байна. Тиймээс энэ бодлого ядуурлыг бууруулах бодлого, ТХЗ-той уялдахгүй байна.
6. Хот байгуулалтын хөтөлбөр нь хүн амын төвлөрлийг сааруулах бодлого, 2030 он гэхэд усгүй болох Улаанбаатар хотын төлөвтэй¹² уялдахгүй байгаа бөгөөд энэ нь хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд ТХЗ, олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалттай уялдахгүй байгаагийн тод жишээ юм.
7. Түүхий нүүрсийг хорьж, гэр хорооллын айлуудыг хотын захын дэд бүтэцгүй бүсэд албадан нүүлгэснээр агаарын бохирдлыг бууруулах боломжгүй, харин эдгээр хүмүүсийг илүү эмзэг байдалд түлхэж байна. “Гэр хорооллын хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих”¹³ төслийн хүрээнд баригдах “орлогод нийцсэн орон сууц”, “уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон сууц” нь цахилгаан, дулаан хангамж мөн л шаардах тул нүүрс нийлүүлэлт, боловсруулах үйлдвэр барих хэрэгцээг өсгөж байна. Үүний улмаас Таван толгойн нүүрсийг замгүй тээвэрлэх, хамгаалалтгүй газар дээр ил овоолон “агуулах” (ЕСБХБ-ны Энержи ресурс Зураг 1), уурхайн нөхөн сэргээлт хийхгүй хэвшсэн практикийг үргэлжлүүлэх зэргээр байгаль орчин, ус, хөрс, бэлчээрийг бохирдуулж, талхлагдсан, цөлжсөн газрыг тэлж байна. Эрдэс баялгийн олборлолтод түшиглэсэн эдийн засгийн өсөлтийн бодлого нь Өмнийг говийн бүсэд түлхүү хэрэгжиж усгүй орчны ховор нөөцийг нь усанд хамгийн хөнөөлтэй уул уурхайд ашиглан улмаар Цөлжилттэй тэмцэх конвенцийн зорилгод нийцэхгүй ч тайландаа уурхайгаас улбаатай цөлжилтийн асуудлыг тусгаддаггүй.
8. Хяналтгүй олборлож буй нүүрсийг тээвэрлэх явц мөн л хяналтгүй болж бэлчээр нутгийг талхлан, хөрс усыг бохирдуулан амьдрах орчныг нь сүйтгэж байгаагаас нутгийн малчид нүүрс тээвэрлэгчдийн хооронд зөрчилдөөн үүсэх, нийгмийн хагарал улс даяар мэдрэгдэх болсон нь ТХЗ-16-ийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай. Үүгээр ч зогсохгүй нүүрс

⁸ ADB, GCF Green Affordable Housing <https://www.adb.org/projects/49169-002/main>

⁹ <http://energy.gov.mn/c/914> мэдээнд байгаа боловч Хөтөлбөр нь яамны сайт, www.legalinfo.mn дээр тавигдаагүй байна.

¹⁰ This also leaves Mongolia less prepared to substantially reduce the number of deaths and illnesses from air pollution in line with SDG Target 3.9 UNECE EPR, Executive Summary, para xxxiv

¹¹ <https://www.legalinfo.mn/law/details/13270?lawid=13270>

¹² Alarming, modeling Ulaanbaatar’s future water demand shows that in all scenarios, the water demand will exceed the current water supply capacity before the year 2021. In the high water demand scenario, Ulaanbaatar’s demand will even exceed the maximum available resources within seven years (Figure 1). http://www.2030wrg.org/wp-content/uploads/2014/07/2030WRG_MONGOLIA.pdf

¹³ https://www.greenclimate.fund/documents/20182/893456/16910_-_ADB_-_

[Ulaanbaatar Green Affordable Housing and Resilient Urban Renewal Project_AHURP_.pdf](#), хуудас 4

тээвэрлэлтийн явцад Гашуунсухайтын замд сард 120 орчим осол гарч, сар бүр 1 хүний амь нас хохирч байна.¹⁴

9. Нийслэлийн агаар, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллыг орон сууцжуулах, дулаан, цахилгаан, ус, цэвэрлэх байгууламж, замын дэд бүтцээр хангах амлалт өгснөөр төслүүддээ дэмжлэг авсан хэдий ч оршин суугчдыг дэд бүтэцгүй хотын захын бүс рүү албадан нүүлгэх, ингэхдээ зохистой нөхөн олговор олгохгүй байх, нөхөн олговрын хэмжээг зөвшөөрөхгүй бол хүч хэрэглэн албадах хуулиар айлган сүрдүүлж нүүлгэж байна. Газар чөлөөлөлтийн хүрээнд газар ба өмчийг хамгийн хямдаар үнэлэх, эзгүйд нь үнэлж тогтоосон үнээ албадах, сүрдүүлэх, худал мэдээлэл өгөх замаар хүлээн зөвшөөрүүлэх, нөхвөрт олгосон газраа дахин төлөвлөлтөд оруулах, ид өвлөөр нүүлгэх¹⁵ зэргээр эрхийг нь зөрчиж байна. АХБ-ны төслийн нүүлгэлтэд өртсөн “газрын гэрчилгээтэй”¹⁶ 900 гаруй өрх (хажуу айлтай нь тооцвол 3000-аад өрх)-өөс зөвхөн 130-аад хүн АХБ-нд гомдол гаргаснаар нөхөн олговрын багцаа хэлэлцэж нэмэгдүүлэх зөвшилцөлд хүрсэн ч нэмэгдүүлж буй хувь хэмжээ нь амьжиргаагаа хадгалах, орон байртай байхад хүрэлцээгүй, шударга биш байна. Хотын төвийн газар, түүний дээрх үл хөдлөх хөрөнгөө хямд үнээр¹⁷ өгч алслагдсан бүсэд нүүж очсон өрхүүдийн эрх дараах байдлаар зөрчигдөж байна: 1) зах зээлийн бус, үзэмжээр тогтоосон үнээр тооцсон нөхөн олговор нь дахин газар авч байшин барих, амьжиргаагаа сэргээхэд хангалтгүй тул орон байртай, амьжиргаатай байх эрх эрсдэж; 2) газрын гэрчилгээ, бүртгэлийг өөрсдөөр нь хөөцөлдүүлж, улмаар нөхөн олговорт тусаагүй бүртгэл, дахин үнэлгээний зардал нэмэгдэх, нөхвөрийг хугацаанд нь олгохгүйгээс үнэ ханш зөрүүгээр давхар хохироох¹⁸; 3) нүүлгэлтээр олгосон газартаа “дахин төлөвлөлтөд орсон” хэмээн гэрчилгээ олгохгүй байх 4) албадан газрыг авсан атлаа “өмчилж авсан газраа өндөр үнээр буцаан худалдсан тул газар өмчлөх эрхээсээ өөрөө татгалзсан” хэмээн өмчлөлийн гэрчилгээ олгохоос татгалзаж газар өмчлөх эрхийг зөрчиж байна; 5) Өмчлөлийн гэрчилгээгээ сэргээн олгоогүй, эзэмшлийн эрх олгож газрын төлбөр авах тохиолдолд амьжиргааг нь өмнөх байдлаас доройтуулах; 6) мэдээллийн тэгш бус байдал үүсгэн нүүлгэлтийн нөхөн олговрын хэмжээг ядуу, эмзэг бүлэгт ялгавартай олгох; 7) сургууль, цэцэрлэгт оруулж чадаагүйн улмаас хүүхдийн сурч боловсрох эрх зөрчигдөх; 8) хүүхдээ цэцэрлэгт оруулж чадаагүй эхийн хөдөлмөрлөх, амьжиргаатай байх эрх; 9) эмнэлэг, нийгмийн халамжийн үйлчилгээнээс холдож хохирох; 10) хашаандаа бичил аж ахуй эрхлэн амьжиргаа залгуулж байсныг татвар төлөлтөөр нотлохгүй бол үнэлэхгүй, нөхвөр олгохгүй байх зэргээр хохироож ядууралд өртөх өрхийн тоог нэмэгдүүлж байна.
10. Нүүлгэлт 2017 онд эхэлсэн атал нүүлгэлтэд өртсөн өрхийн амьжиргааг сэргээх хөтөлбөр нь 2019 оны 8-р сар гэхэд бэлэн болоогүй байгаа нь АХБ/ЕХОБ-ны төслүүд банкуудын хамгааллын бодлогыг зөрчиж,¹⁹ уур амьсгалын өөрчлөлтийг хянах, ядуурлыг бууруулах, ТХЗ-д нийцэхгүй хөгжлийн хөтөлбөрийг олон улсын банкуудаас санхүүжүүлж байгаагийн жишээ юм. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөгүй хэрэгжүүлж буй “бүтээн байгуулалт” нэртэй төслүүд ЭЗНСОУП-аар хамгаалагдсан бүх эрхийг түгээмлээр зөрчиж байгаагийн нэг тод жишээ бол нийслэл ба аймгийн төвүүдэд нөхөн олговоргүй,

¹⁴ “Тавантолгойн бүлэг ордын нүүрс олборлох, тээвэрлэх үйл ажиллагааны хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ”. БИХ, ХЭҮК, НҮБХХ, 2018 он.

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/216> 42.4.Хувийн гэр, орон сууцны хашааны газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авах тохиолдолд түүнийг чөлөөлөх ажлыг зөвхөн 5 дугаар сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийнэ.

¹⁶ Газрын тухай хуулинд өмчлөх, эзэмших, ашиглах гэрчилгээтэй газрын харилцааг зохицуулж уламжлалаар эзэмшиж, ашиглаж ирсний зохицуулаагүй, эрхийг хамгаалаагүй болно <https://www.legalinfo.mn/law/details/216>

¹⁷ Ibid, 43.2..... уг газраас салгаж үл болох барилга байгууламж, бусад эд хөрөнгийг тухайн үеийн ханшаар үнэлсэн үнэ, газрыг чөлөөлөх зардлыг тусгана.

¹⁸ Хэрэглээний үнийн индекс дундаж өсөлт 8.1%, инфляц сарын 0.6%-тай нөхцөлд 3-6 сар хоцроож нөхөн олговрыг олгож байгаа нь ноцтой хохироож байгаа юм. <http://www.nso.mn/content/2120#.XYsTMigzblU>

¹⁹ Одоог хүртэл хэрэгжиж ирсэн орон сууцжуулах ипотекийн төслийн дүнгээс үзвэл гэр хорооллын явуу өрхүүд ипотекийн зээл авах чадамжгүй, харин чинээлэг өрхүүд 2-3 дахь сууц авч баян ядуугийн ялгаа улам гүнзгийрч байгаа тухай мэдээлэл байна.

мэдээлэлгүй, нөлөөлөлд өртөгчийн оролцоогүй явагдаж буй газар албадан чөлөөлөлт²⁰ бөгөөд үүнийг АХБ-ны Хариуцлагын механизмд гаргасан 150 хүний гомдол,²¹ Монголын Эмнести интернэшнл ТББ-ын тайлан²² гэрчилнэ.

Олборлолтоос боловсруулалт руу давшилт

11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар 2012 оноос эхлэн СНҮ хийхээр зохицуулсан ч энэ хугацаанд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт 6 том хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн ч нэг нь ч СНҮ хийгээгүй. Уул уурхайн салбарт боловсруулах, баяжуулах үйлдвэрлэл яаравчлан эхлүүлэхдээ хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах, газар өмчлөх, уламжлалт байгалийн нөөц ашиглах, амьжиргааны эх үүсвэртэй, орон гэртэй байх хот хөдөөд ялгаагүй зөрчигдөж буй эрхүүдэд хэрхэн нөлөөлөх үнэлгээ хийгээгүй, хамгаалах төлөвлөгөөгүй ажиллаж байна. Нөхөн олговор олгох, нүүлгэх үндэсний журам стандарт байхгүй²³ тул нөхвөрийн дур зоргоор тооцож зөвшөөрөхгүй бол албадан нүүлгэх, хүч хэрэглэхээс хамгаалагдаагүй, албадан нүүлгэлтийг эсэргүүцвэл цагдаа хүч хэрэглэх зохицуулалттай хэрэгжиж байна. Газар ашиглах гэрчилгээгүй хүний асуудлыг орхигдуулсан тул уламжлалаар хот суурин нэг хашаанд, хөдөөд өвөлжөөн дээр хот айлаар амьдарч буй өрхүүдийн орон гэртэй байх эрх хамгаалалтгүй болсон. Олборлох, боловсруулах үйлдвэрлэлд лиценз олгоходоо тухайн суурингийн хүн амын амьжиргааны эх үүсвэр болох газрын хэдий хэмжээг авбал тогтвортой хөгжих нөхцөл алдагдахгүй байх тооцоо, үнэлгээ хийхгүй байна. Жишээлбэл, Даланжаргалан сумын газар нутгийн 70 гаруй хувьд нь 97 тусгай зөвшөөрөл бүхий 23 компани, 10 гаруй баяжуулах үйлдвэр²⁴, Заамар сумын нийт нутгийн 60 хувь, Хайлааст багийн нутгийн 70 хувьд олборлох тусгай зөвшөөрөл олгогдсон байгаа нь тухайн суурингийн хүн амын хөгжих, эрүүл амьд явах, амьжиргаа залгуулах өөрийн аж ахуйтай байх эрх зөрчигдхөөс гадна сум, багийн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг тооцохгүй, ТХЗ-уудтай уялдуулахгүй байгаагийн нотолгоо юм.
12. Уул уурхайн салбарт боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого хэрэгжүүлэхдээ мөрдөх журам, стандарт урьдчилж батлаагүй, БОНБННҮ шаардахгүй эхлүүлсэн нь байгаль орчны бохирдол, усны хомсдол үүсгэж байгаа бөгөөд энэ нь бороогүй зун сул зогссон боловсруулах үйлдвэрийн жишээн дээр харагдсан. Уурхайн бүс дэх агаар, усны чанарын хяналт байхгүй, МУ-ын ус, агаарын бохирдол болон зарим химийн цацраг идэвхт бодисын зөвшөөрөгдөх хэмжээг олон улсын стандартаас дордуулан тогтоох замаар (Хавсралт 4) ноцтой зөрчлийг нуун дарагдуулж байгаа нь уурхайн орчмын хүн амын эрүүл байх, эрүүл аюулгүй хүнс хэрэглэх эрхийг ноцтой зөрчиж байна. Мөн МУ-ын MNS 4585:2016 стандартаар тогтоосон агаарын чанарын индексийг тооцох аргачлал нь бодит эрсдлийг нуун дарагдуулахаар байна²⁵. Энэ нь ТХЗ-ууд 1, 2, 3, 6, 13, 15 хэрэгжихгүй байх нөхцөл бүрдэж байна.
13. НҮБ-ын Уугуул хүмүүсийн эрхийн тухай тунхаглалаар хамгаалагддаг эртний нүүдэлч ахуй соёлтны нүүдэллэх эрхийг уул уурхай, дэд бүтцийн төслүүд зөрчиж байна. Тухайлбал, малчинд 60 жилээр олгосон өвөлжөө, түүнийг дагалддаг бэлчээр, усны нөөц бүхий газарт лиценз давхардуулан олгож газрыг нь авахдаа малчдын амьжиргааны үндсэн хэрэглүүр болох малын бэлчээрт “газрыг газраар нөхөх” зарчим үйлчлэхгүй нөхөн олговорт зөвхөн өвөлжөөний газар олгох суурин соёлын бодлого барьж байгаа нь дараах зөрчлийг дагуулж байна. Үүнд: 1) нүүдэллэх бэлчээргүй болсноос мал маллагаагаар амьдрах боломжгүй болж ядуурах, орон гэргүй болж нутгаасаа дүрвэх; 2) зөвшөөрөлтэй ба зөвшөөрөлгүйгээр бусдын бэлчээр эзлэх, үүний улмаас малчдын дунд мөргөлдөөн тэмцэл гарах; 3) бэлчээр, усны нөөцийн хомсдлоос

²⁰ <https://www.adb.org/projects/45007-004/main>,

²¹ <https://www.adb.org/projects/45007-004/main>

²² <https://www.amnesty.org/download/Documents/ASA3049332016ENGLISH.PDF>

²³ 2018 оны 7-р сард батлагдсан Засгийн газрын 22-р тогтоол нь олон зуун өрх хохирсноос хойш батлагдсан зөвхөн хот сууринд хамаарах зохицуулалт бөгөөд хэрэгжилт нь олон улсын стандартад нийцсэн эсэхийг нягтлах шаардлагатай болно.

²⁴ <https://ikon.mn/n/1k84>

²⁵ 1. (UNECE EPR, page xxxiv, para 6).

үүдэж даац хэтрэн талхлагдсан, цөлжсөн газрын хэмжээ тэлэх; 4) нүүдлийн мал аж ахуй, нүүдэлч ахуй соёл устгах; 5) хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байна. Хөдөө орон нутагт амьжиргаатай байх суурь нөхцлүүдийг бүрдүүлж хамгаалахын оронд Улаанбаатарт шилжин суурьших хөдөлгөөнийг 2020 он хүртэл хорих шийдвэр²⁶ гаргасан нь хөгжилд сөрөг нөлөөтэй, эмзэг бүлэгт ээлгүй, UPR-ын II циклийн 108.144 зөвлөмжтэй²⁷ болон бусад бодлогуудтай уялдаагүй бодлогын бас нэг тод жишээ юм.

14. НҮБ-ын Бизнес ба хүний эрх удирдамжийг хэрэгжүүлэх Үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүлсэн хэдий ч бизнесийн нөлөөлөх хүрээг хөдөлмөрлөх эрх, ажлын байран дахь эрхийн зөрчил, хүүхдийн хөдөлмөрлөх эрхийн хүрээгээр явцууруулан авч үзэж, улмаар уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбараас хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьд байх, эрүүл мэндээ хамгаалуулах, уламжлалт бэлчээр усаа ашиглах, нүүдэллэх эрх ба нүүдэлч ахуй соёлоо хадгалах, өвлүүлэх эрхүүд ноцтой зөрчигдөж байгааг хүлээн зөвшөөрч тусгахаас зайлсхийх магадлалтай байна.
15. Нэг суманд уул уурхай эрхлэх лицензийг олгоходоо газар нутгийнх нь 80-90%-д олгож тухайн сум тогтвортой, иргэнийхээ суурь эрхүүдийг ханган хөгжих орон нутгийн засаг захиргааны бодлого, хөтөлбөрийг үл харгалзан олонтаа тохиолдолд илт ашиг сонирхлын зөрчилтэй, авилгатай холбоотой этгээдэд олгож байна. Нутгийн хүн ам зөрчилтэй компанийг хуулийн хариуцлагад татахад дараах хүндрэл тулгарч байна. Үүнд: 1) шүүх, хууль зүйн туслалцааны хүртээмж аймаг, сумын түвшинд тоон²⁸ ба чанарын хувьд хангалтгүй; 2) шүүхэд компаний эсрэг нэхэмжлэл гаргахад хэрэг үйлдсэн газарт биш тухай компанийн бүртгэлээр хэргийн харьяалал тогтоож уул уурхайн зөрчлийг Улаанбаатарт ирж нэхэмжлэхэд хүрч байна. Энэ нь тухайн иргэдийн шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлэх зардлыг улам өсгөж байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын иргэн СГКТ компанийн хууль зөрчиж авсан лицензийн хэргийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд 2018 онд нэхэмжилж, улмаар нэг талдаа 910 км замыг 33 удаа туулж шүүх хэлэлцүүлэгт оролцсон ч нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, хэргийг хаасан нэгэн түгээмэл жишээ байна. 3) Компаниуд шүүхэд нөлөөлж, хэргийг хэрэгсэхгүй болгуулах, хэрэг хянан шийдвэрлэх явцыг илт удаашруулан цаг хожиж үйл ажиллагаагаа эхлүүлэх, компанийн нэр хүндэд халдсан хэргээр шүүхэд татах явдал түгээмэл. 4) Нутаг ус, өмч, өөрийн болон бусдын эрхийг хамгаалан тэмцэж буй хүний эрхийг хамгаалагчдад уурхайн үйл ажиллагааг саатуулсан нэрээр бизнесийн хохирол гэгч өндөр үнэ тогтоож нэхэмжлэх, төлүүлэхээр сүрдүүлэх, дарамтлах, халдах зөрчил түгээмэл болсон.

Зөвлөмж: 1) Одоо хэрэгжиж буй эрчим хүч, уул уурхай ба хүнд үйлдвэр, зам тээвэр, бүх дэд бүтцийн хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд Стратегийн нөлөөллийн үнэлгээ хийж хүний эрхийн болон БО-ны конвенциуд, уур амьсгалын өөрчлөлтийн ҮТХН, ТХЗ мөн түүнчлэн БОГҮ-ний тайлан зөвлөмжүүдэд нийцүүлэн сайжруулах;

2) Олон улсын стандартад нийцсэн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын үндэсний журам стандарт баталж аймаг, нийслэлийн газар, хот төлөвлөлт, уул уурхай, дэд бүтэц ба аливаа төсөлд лиценз олголтын ӨМНӨ нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд багтаан хэрэгжүүлэх;

3) Сөрөг нөлөөллийн өндөр эрсдэл (А Category)-тэй төслүүдэд хүний эрхийн нөлөөлөл болон эрхийг хамгаалагчдын эрсдлийн үнэлгээ хийх эрх зүйн орчин бүрдүүлэх, хэрэгжүүлэх.

²⁶ <http://www.ulaanbaatar.mn/Home/Docdetail?dataID=28132>

²⁷ 108.144. Хотын төвүүдэд нийгмийн хамгийн эмзэг бүлгийн хүмүүс, түүний дотор орон нутгаас шилжин ирсэн хүмүүс нийтийн суурь үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг хангах замаар хотын төвүүдэд тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авах /Испани/

²⁸ МУ-д 339 сум байдаг бөгөөд нийт аймаг ба сум дундын шүүхийн тоо 29 байсан дээр нэмэгдсэн ч сумын хүн амын шүүхэд хохирлоо нэхэмжлэх боломж хаалттай хэвээр байна.

- 4) Байгаль орчны зөрчил гарсан, гарч болзошгүй газарт нь хэргийг хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт бий болгох;
- 5) Байгаль орчны талаарх мэдээлэл, гомдлыг авч хэлэлцэх, шийдвэрлэх эрхтэй, хараат бус байгаль орчны Омбудперсоны эрх мэдэл бий болгох.²⁹
- 6) Уламжлалт нүүдэлч ахуй соёлыг хамгаалах, нүүдэлч хүн амын нүүдэллэн мал маллах зайлшгүй шаардлага ба уламжлалаар зохицуулагдан ирсэн бэлчээрийн эрхийг нь хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох үйл ажиллагааг Бизнес ба хүний эрх Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөнд суулган хэрэгжүүлэх;
- 7) Уул уурхай, эрчим хүч, барилга ба дэд бүтцийн салбарт хамаарах хүний эрүүл мэндэд нөлөөтэй химийн хортой болон аюултай бодисын MNS улсын стандартыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын стандартуудад нийцүүлэн хянан шинэчлэх.